72

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2011 оны 02 сарын 02 өдөр | Дугаар 1/44 | Улаанбаатар хот

## Заавар батлах тухай

Засгийн Газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэнд Монгол Улсаас гарах сануулга өгөх, түүнийг хэрэгжүүлэх заавар"-ыг нэгдүгээр, ""Гарах сануулга"-ын загварыг хоёрдугаар, "Гарах сануулга өгөхөөр шилжүүлсэн бүртгэл" болон "Гадаадын иргэнд гардуулсан гарах сануулгын бүртгэл"-ийн дэвтрийг гурав, дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга /Ч.Эрдэнэбат/, Хяналтын хэлтсийн дарга /Н.Баянмөнх/ нарт үүрэг болгосугай.

3. "Гарах сануулга өгөхөөр шилжүүлсэн бүртгэл" болон "Гадаадын иргэнд гардуулсан гарах сануулгын бүртгэл"-ийн дэвтэр хэвлүүлэх зардлыг Газрын төсвөөс гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Л.Бямбадорж/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨРӨН

0000101

41

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын 2011 оны А/44 дугаар тушаалын хавсралт

# ГАДААДЫН ИРГЭНД ГАРАХ САНУУЛГА ӨГӨХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү заавар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгох гадаадын иргэний паспорт, баримт бичгийг хяналтын улсын байцаагчид шилжүүлэх, хяналтын улсын байцаагч нь гадаадын иргэнд Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг гардуулах, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн талаар тайлагнахад энэхүү зааврыг дагаж мөрдөнө.

## Хоёр. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгохоор шийдвэрлэх

2.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгох үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн Зөвшөөрөл, бүртгэлийн мэргэжилтэн нь уг иргэний материалыг Визийн тасгийн даргаар хянуулан Хяналтын хэлтсийн даргад шилжүүлнэ.

2.2. Энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан мэргэжилтэн нь аль улсын иргэнийг хуулийн ямар үндэслэлээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгохоор шийдвэрлэж байгаа талаар дэлгэрэнгүй тэмдэглэлийг бүртгэлийн дэвтэрт үйлдэн Хяналтын хэлтсийн даргад паспорт, паспортыг орлох баримт бичиг, бусад холбогдох материалыг шилжүүлнэ.

2.3. Хяналтын хэлтэст шилжүүлсэн материал нь хууль тогтоомжид заасан үндэслэл хангаагүй болон бусад холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу гадаадын иргэнд холбогдох материалыг хүлээн авахгүй.

2.4. Хяналтын улсын байцаагч нь энэхүү зааврын 2.1 дэх хэсэгт заасны дагуу Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсээс шилжүүлснээс гадна хяналт шалгалтын явцад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3 дахь хэсэгт заасан гадаадын

иргэний зөрчлийг илрүүлсэн тохиолдолд хууль тогтоомжийн хүрээнд гарах сануулгыг гардуулна.

## Гурав. Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг сануулах

3.1. Гадаадын иргэний паспорт, паспортыг орлох баримт бичиг, бусад материалыг хүлээн авсан хяналтын улсын байцаагч нь дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

3.1.1. Гадаадын иргэний паспорт болон бусад холбогдох материалыг уг гадаадын иргэнд Монгол Улсаас гарах сануулгыг гардуулан өгөх хүртэл хугацаанд хадгалах;

3.1.2. Гарах сануулгыг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг материалд нь хавсаргах, 2 дахь хувийг гарах сануулга авч байгаа гадаадын иргэнд өгнө;

3.1.3. Гадаадын иргэнд холбогдох материалыг Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсээс хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 5 хоногийн дотор Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу уг иргэнд Монгол Улсаас сайн дураараа гарахыг сануулж, гарах тухай сануулгыг биечлэн гардуулан энэ талаар бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөх;

3.1.4. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн иргэн 10 хоногт багтан тус улсаас гарах үүрэгтэй тухай болон гараагүй тохиолдолд мөн хуулийн 37.1.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсаас албадан гаргагдах үндэслэл болохыг гадаадын иргэнд сануулах;

3.1.5. Гадаадын иргэн гарах сануулга хүлээн авсан тухай гарын үсэг зурахаас татгалзвал татгалзсан шалтгааныг заасан тайлбар бичиж гарах сануулгад хавсаргах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзсан нь гарах сануулгыг биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй;

3.1.6. Хуульд заасан хугацаанд багтаж Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарч явахаас зайлсхийсэн гадаадын иргэнийг хяналтын улсын байцаагч Монгол Улсаас албадан гаргах дүгнэлт үйлдэн, албадан гаргах ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлэх;

3.1.7. Гадаадын иргэн гарах сануулга хүлээн авахаас болон паспорт, паспортыг орлох баримт бичгийг тус Газарт хадгалуулан хяналтын улсын байцаагчийн дуудсан цагт ирэхээс зайлсхийсэн тохиолдолд тухайн гадаадын иргэнийг олж илрүүлэх, хуульд заасан хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

3.1.8. Гарах сануулга хүлээн авсан гадаадын иргэн хуульд заасан хугацаанд багтаж тус улсаас гарсан эсэх талаар Хяналтын хэлтсийн даргад ажлын 3 хоногийн дотор илтгэх хуудсаар танилцуулах;

3.1.9. Гарах сануулга гардуулсан талаархи нэгдсэн бүртгэлийн дэвтэрт нарийвчилсан тэмдэглэл хөтлөх, паспорт хяналтын нэгдсэн сүлжээнд мэдээлэл оруулах;

3.2. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгохоор шийдвэрлэн гарах сануулга гардуулсан гадаадын иргэдийн талаар Газрын даргад сар тутам илтгэх хуудсаар тайлагнана.

--------ooOoo---------

76

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗАР
17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа
Утас:9314-1018, Вэбсайт:www.immigration.gov.mn

№ 0000001

## ГАРАХ САНУУЛГА

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу.......................... Улсын иргэн ..........................................Таны Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг /олгохоос татгалзсан, зөвшөөрлийн хугацаа сунгахаас татгалзсан, зөвшөөрлийг хүчингүй болгосон/ тул Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35.2-д заасны дагуу гарах сануулгыг авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор Монгол Улсаас сайн дураараа гарах үүрэгтэй болохыг сануулж байна.

Хэрэв дурдсан хугацаанд тус улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй бол Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсаас албадан гаргах болохыг Танд анхааруулж байна.

### Notice for foreigners

This is to notify that you are required to exit Mongolia voluntarily within 10 days after receiving the Notice to exit the country (Art. 35.2 of the Law on Status of Foreign Citizens), as your residence permit for (private purpose has not been granted, you have been refused an extension or the permit is invalidated) in accordance with Article 27.3 of the Law on Status of Foreign Citizens. Failure to follow the Notice to exit the country voluntarily is a subject to deportation from Mongolia (Article 37.1.8).

### Памятка для иностранных граждан

Мы напоминаем вам о том, что вы обязаны добровольно выехать из страны в течение 10 суток (ст.35.2 Закон о правовом положении иностранных граждан) с момента получения данной Памятки так как вам разрешение на нахождение в Монголии по частным делам /отказано выдать отказано продлить срок или аннулировано/ в соответствии со ст. 27.3. Нарушение ведет к выдворению из страны (ст. 37.1.8)

根据"外国公民法律地位法"第27条第3款之规定，如果您在蒙古国的居留许可到期或失效（包括申请或办理延期时被拒绝、居留许可作废等），则须根据该法第35条第2款之规定在收到离境通知后的10天内自行离境，否则将根据该法第37条第1款第8项之规定被驱逐出境。

ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ: / /

Гарах сануулгыг хүлээн авсан: / /

Огноо........................................

75

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗАР**

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа

Утас:9314-1018, Вэбсайт:www.immigration.gov.mn

№ ______________ 0000001

## ГАРАХ САНУУЛГА

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу.......................... Улсын иргэн ..............................................Таны Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг /олгохоос татгалзсан, зөвшөөрлийн хугацаа сунгахаас татгалзсан, зөвшөөрлийг хүчингүй болгосон/ тул Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35.2-д заасны дагуу гарах сануулгыг авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор Монгол Улсаас сайн дураараа гарах үүрэгтэй болохыг сануулж байна.

Хэрэв дурдсан хугацаанд тус улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй бол Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсаас албадан гаргах болохыг Танд анхааруулж байна.

**Notice for foreigners**

This is to notify that you are required to exit Mongolia voluntarily within 10 days after receiving the Notice to exit the country (Art. 35.2 of the Law on Status of Foreign Citizens), as your residence permit for (private purpose has not been granted, you have been refused an extension or the permit is invalidated) in accordance with Article 27.3 of the Law on Status of Foreign Citizens. Failure to follow the Notice to exit the country voluntarily is a subject to deportation from Mongolia (Article 37.1.8).

**Памятка для иностранных граждан**

Мы напоминаем вам о том, что вы обязаны добровольно выехать из страны в течение 10 суток (ст.35.2 Закон о правовом положении иностранных граждан) с момента получения данной Памятки так как вам разрешение на нахождение в Монголии по частным делам /отказано выдать отказано продлить срок или аннулировано/ в соответствии со ст. 27.3. Нарушение ведет к выдворению из страны (ст. 37.1.8)

根据"外国公民法律地位法"第27条第3款之规定，如果您在蒙古国的居留许可到期或失效（包括申请或办理延期时被拒绝、居留许可作废等），则须根据该法第35条第2款之规定在收到离境通知后的10天内自行离境，否则将根据该法第37条第1款第8项之规定被驱逐出境。

ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ: / /

Гарах сануулгыг хүлээн авсан: / /

Огноо..........................................

Гадаадын иргэн, ха[illegible]атын асуудал эрхлэх газрын [illegible]ын 2011 оны А/44 дугаар тушаалын [illegible]аар хавсралт

**Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсээс хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан буюу хүчингүй болгохоор шийдвэрлэж Хяналтын хэлтэст шилжүүлсэн гадаадын иргэний бүртгэл**

| № | Гадаадын иргэний овог, нэр | Иргэний харьяалал | Татгалзсан үндэслэл | Шилжүүлсэн мэргэжилтний нэр | Оноо | Хүлээн авсан гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн нэр | Хавсаргасан материал, хуудасны тоо | Шийдвэрлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын 2017 оны [illegible] дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

## Гарах сануулга гардуулсан гадаадын иргэний бүртгэл

| № | Гадаадын иргэний нэр | Иргэний харьяалал | Төрсөн он, сар, өдөр, | Гарах сануулгын үндэслэл | Гарах сануулга гардуулсан огноо | Гардуулсан хяналтын улсын байцаагчийн нэр | Шийдвэрлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |